



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 7/204

Улаанбаатар хот

Г Т

Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалт, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний 4 дэх хөтөлбөр 2012-2016”, Эх, хүүхдийн эндэгдлийн асуудлыг хэлэлцсэн удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Энхболд)-т үүрэг болгох нь:

1.1 Эх барих, эмэгтэйчүүд, хүүхдийн чиглэлээр гарсан тушаал шийдвэр, заавар журмыг хянаж, шаардлагатай эрх зүйн баримт бичгийг шинэчлэн боловсруулж, 2016 оны 7 дугаар сард багтаан батлуулах;

1.2 Аймгийн хүүхдийн болон эх барих, эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн, зөвлөх эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг шинэчлэн боловсруулж 2016 оны 7 дугаар сард багтаан батлуулах;

1.3 Яамны газар, хэлтсийн дарга нар, холбогдох мэргэжилтнүүдийг эх, хүүхдийн эндэгдэл өндөр аймгуудад томилон ажиллуулах;

1.4 Хүүхдийн анагаахын болон эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүд, зөвлөх эмч нарын нийслэлийн амаржих газрууд болон аймгийг хариуцан ажиллах хуваарийг шинэчлэн, ажлын удирдамжийг батлаж, мөрдүүлэх;

1.5 Эх, хүүхдийн эндэгдэл гарсан аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын болон нэгдсэн эмнэлгийн дарга нарын мэдээллийг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох арга хэмжээ авч ажиллах;

1.6 Эх, хүүхдийн эндэгдэл тогтвортой буурахгүй байгаа аймгуудад Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв болон амаржих газраас туршлагатай эмч нарыг илгээн орон нутгийн эмч, мэргэжилтнүүдийг ажлын байран дээр нь сургаж дадлагажуулах, тухайн аймгаас эмч, мэргэжилтнүүдийг дээрхи эмнэлгүүдэд солбилцуулан сургаж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

080742

1.7 Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний явцын талаар Сайдын зөвлөлийн хурлаар 6 дугаар сард багтаан хэлэлцүүлэх.

Хоёр. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Хүүхдийн анагаахын мэргэжлийн салбар зөвлөл (Ш.Энхтөр), Эх барих эмэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөл (Т.Эрхэмбаатар)-д тус тус үүрэг болгох нь:

2.1 "Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах арга зам" сэдэвт мэргэжлийн зөвлөлдөх уулзалтыг 2016 оны 06 дугаар сарын 10-ны дотор зохион байгуулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал дүгнэлтийг аймаг тус бүрээр гаргаж, танилцуулах;

2.2 "Эх барихын халдварт, үжлийн оношилгоо, эмчилгээ"-ний зааврыг боловсруулан 2016 оны 7 дугаар сард багтаан, баттуулах;

2.3 Эх, хүүхдэд үзүүлэх яаралтай тусlamжид алсын зайн оношлогоог өргөжүүлэх, тогтмолжуулах үйл ажиллагааг зохион байгуулж, арга зүйгээр хангах, заавар, зөвлөгөөг цаг алдалгүй шуурхай өгч, үр дүнг тооцох.

Гурав. Стратегийн бодлого төлөвлөлтийн газар (Р.Оюунханд), Санхүү, эдийн засгийн хэлтэс (Т.Баярсайхан)-т үүрэг болгох нь:

3.1 Эх, хүүхдийн тусlamж, үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, жирэмснээс сэргийлэх эм, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, 2017 оны төсөвт шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг суулгах.

Дөрөв. Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг)-т үүрэг болгох нь:

4.1 Эх, хүүхдийн эндэгдэл гарсан Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн газрын дарга наарт хариуцлага тооцох тухай бопон Эрүүл мэнд, спортын сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, ажлаа эрчимжүүлэх талаарх албан даалгаврыг аймгийн Засаг дарга наарт хүргүүлэх;

4.2 "Жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үеийн ноцтой хүндрэлийг бүртгэх, мэдээлэх журам"-ын 2.1-р заалтыг хангалтгүй биелүүлсэн Нийслэл, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн эрүүл мэндийн газар, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн удирдлагад тус тус хариуцлага тооцох.

Тав. Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хүрээлэн (Ь.Цогтбаатар)-д тус тус үүрэг болгох нь:

5.1 Төрийн сангийн тэтгэлгээр 2012-2015 онд төгссөн эмч нар захиалгын дагуу орон нутагт очиж ажилласан байдалд үнэлгээ хийж, дүнг танилцуулах;

5.2 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад дутагдалтай байгаа эх барих, эмэгтэйчүүд, нярайн болон хүүхдийн эмчийг төрийн сангийн тэтгэлгээр сургаж бэлтгэх, арга хэмжээ авах;

5.3 Эх барих, эмэгтэйчүүд, хүүхдийн эмч, сувилагч, эх баригч наарт зориулсан зайн сургалтыг холбогдох эрүүл мэндийн байгууллагатай хамтран тогтмол явуулж, үр дүнг тооцох;

5.4 Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, оюутнуудад эхийн ноцтой хүндрэл, эхийн эндэгдэл, хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг мэдээллийн бүх сувгийг ашиглан зохион байгуулах;

5.5 Эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулахад мэргэжлийн арга зүйгээр хангаж, хамтран ажиллах.

Зургаа. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал наарт үүрэг болгох нь:

6.1 Эрхтэн тогтолцооны эмгэгтэй, эрчимт эмчилгээ, яаралтай тусlamж шаардлагатай байгаа жирэмсэн эмэгтэй, төрсөн эх, хүүхдийг харьяалал харгалзахгүйгээр, хугацаа алдалгүй хүлээн авч үйлчлэх;

6.2 Төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн арга зүйгээр тогтмол хангаж ажиллах.

Долоо. Эмгэг судлалын үндэсний төв (Г.Уянга)-д үүрэг болгох нь:

7.1 Эх, хүүхдийн эндэгдлийн тохиолдлын шинжилгээний хариуг холбогдох журамд заасны дагуу цаг хугацаанд нь шуурхай гаргаж, эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэх, орон нутгийн эмгэг судлаач эмч нарын шинжилгээний дүгнэлтэд хяналт тавьж ажиллах;

7.2 Аймгуудын эмгэг судлаач эмч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллах.

Найм. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга наарт үүрэг болгох нь:

8.1 Эх барих, эмэгтэйчүүд, хүүхдийн ерөнхий мэргэжилтэн-зөвлөх эмчээр туршлагатай эмчийг томилон ажиллуулж, орон нутгийн хэмжээнд мэргэжлийн зөвлөгөө өгөх, эмч мэргэжилтнүүдийг мэргэжлийн арга зүйгээр хангах;

8.2 Эх барих, эмэгтэйчүүд болон хүүхдийн туршлагатай эмч нарыг 6-8 дугаар саруудад ажиллуулахаар ээлжийн амралтыг зохицуулах;

8.3 Эмнэлгийн чанарын апбанаас эх, хүүхдийн тусlamж, үйлчилгээ, эмнэлгийн тусlamж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд сар бүр хяналт хийж, зөвлөмж өгөх ажлыг хэвшүүлэх;

8.4 Эх барихын болон хүүхдийн яаралтай тусlamжийн бэлэн байдлыг хангах, амь тэнссэн үед үзүүлэх яаралтай тусlamжийн мэдлэг, ур чадварыг бүх эмч, эмнэлгийн мэргэжилтэнд эзэмшүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

8.5 Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйн хяналтын чанарыг сайжруулахын тулд өрх, сумын эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, амаржих газруудын хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг идэвхижүүлэх;

8.6 Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр мэдээлэл, сургалт сурталчилгаанд өсвөр үеийнхэн, оюутан залуучууд, 2 хүртэлх насын хүүхэдтэй эхчүүдийг бүрэн хамруулах, эрхтэн тогтолцооны хүнд хэлбэрийн хавсарсан эмгэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй, нийгмийн эмзэг булгийн болон эх барихын ужиг дурьдатгалтай эмэгтэйчүүдийн жирэмснээс хамгаалах эм, хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх;

8.7 Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын хариуцлага болон ёс зүй, харьцаа хандлагыг сайжруулах ажлыг тогтмол зохион байгуулан, зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцож ажиллах;

8.8 Эх, хүүхдийн эндэгдэл, эхийн ноцтой хүндрэлийг хэлэлцэх багийн хурлыг тогтсон хугацаанд хийж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн, үр дүнг тооцож ажиллах, эхийн эндэгдлийн холбогдох бичиг баримтыг нэг сарын дотор, эхийн ноцтой хүндрэлийн хурлын тэмдэглэлийг дараа улирлын эхний сарын 05-ны дотор Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанад тус тус хүргүүлж байх;

8.9 Орон нутгийн Засаг даргын тамгын газартай хамтран иргэний шилжилт хөдөлгөөний улмаас эх, хүүхэд эмнэлгийн тусlamж, үйлчилгээнээс хожимдохоос сэргийлэх арга хэмжээг авах.

Ес. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн 2016 оны үйл ажиллагааг үнэлэхдээ эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнг харгалзаж үнэлэхийг Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.

Арав. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг удирдлагын зөвлөлийн хурлаар 14 хоног тутамд тогтмол хэлэлцүүлж, зайлшгүй авах арга хэмжээний талаар танилцуулж байхыг Төрийн нарийн бичгийн даргад даалгасугай.

САЙД

С.ЛАМБАА

